



# ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



---

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАГЧИЙН 2021  
ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ АУДИТЫН ДҮГНЭЛТ**

---

2020 ОН

| Аудитыг гүйцэтгэсэн:                                                                                                                                                        | Агуулга                                                     | Хуудас |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|--------|
| <p>Өмнөговь аймаг дахь<br/>Төрийн аудитын<br/>газрын дарга бөгөөд<br/>тэргүүлэх аудиторын албан<br/>үүргийг түр орлон гүйцэтгэгч<br/><br/>Т.Хонгорзул</p>                   | Товчилсон үгийн тайлбар                                     | 3      |
|                                                                                                                                                                             | Ерөнхий зүйл                                                | 4      |
|                                                                                                                                                                             | Нэг. Төсвийн тусгай шаардлага,<br>төсвийн хүрээний мэдэгдэл | 5      |
|                                                                                                                                                                             | Хоёр. Орон нутгийн төсвийн нийт<br>орлого                   | 6-8    |
|                                                                                                                                                                             | Гурав. Орон нутгийн төсвийн нийт<br>зарлага                 | 9      |
| <p>Хэлтсийн дарга бөгөөд<br/>аудитын менежерын албан<br/>үүргийг түр орлон гүйцэтгэгч<br/>С.Одончимэг</p>                                                                   | Дөрөв. Орон нутгийн төсвийн хөрөнгө<br>оруулалт             | 10-11  |
| <p>Ахлах аудитор:<br/>Г.Шижирболд</p>                                                                                                                                       | Тав. Орон нутгийн хөгжлийн сан                              | 11     |
| Аудитор                                                                                                                                                                     | Ерөнхий дүнгэлт.                                            | 12     |
| <p>Д.Сүрэнжаргал<br/>Ж.Болормаа<br/>Ш.Отгонбаяр<br/>Ч.Наранбадрах<br/>Н.Хулан<br/>Э.Жаргал<br/>Т.Хишигбат</p>                                                               | Хавсралт.                                                   | 13-18  |
| 2020 оны 11 дүгээр сар                                                                                                                                                      |                                                             |        |
| <p>Аудитын тайлан,<br/>дүгнэлттэй холбоотой<br/>асуудлаар нэмж<br/>тодруулах, асууж<br/>лавлах зүйл байвал<br/>70533539, 70533552<br/>дугаарын утсаар харилцана<br/>уу.</p> |                                                             |        |
| <p>Тайланг ӨМТАГ-ын<br/><a href="mailto:www.umnugovi@audit.gov.mn">www.umnugovi@audit.gov.mn</a><br/>цахим хуудаснаас үзнэ үү.</p>                                          |                                                             |        |
| <p>Хаяг: Нутгийн удирдлагын<br/>ордон, 3 давхар, 303 тоот.</p>                                                                                                              |                                                             |        |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

|          |                                                          |
|----------|----------------------------------------------------------|
| МУЗГ     | Монгол улсын Засгийн газар                               |
| АТБӨЯХ   | Атво тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл                 |
| АТБӨЯХАТ | Атво тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татвар |
| НӨАТ     | Нэмэгдсэн өртгийн албан татвар                           |
| НӨАТУС   | Нэмэгдсэн өртгийн албан татварын уялдуулсан систем       |
| ТЕЗ      | Төсвийн ерөнхийлөн захирагч                              |
| НДШ      | Нийгмийн даатгалын шимтгэл                               |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                                |
| ОНТХО    | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт                    |

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Өмнөговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасны дагуу Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар дүгнэлт гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2021 оны аймгийн төсвийн төслийг 2020 оны 11 дүгээр сарын 23-ний өдөр, урьдчилсан тооцоо судалгаа, шинжилгээгүй ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх”, 31 дүгээр зүйлийн 31.4 “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана”-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудит нь цаг хугацаа, нөхцөл байдлын /COVID-19/ хувьд хязгаарлагдмал, хариуцагч талаас аудитын баримтжуулалтын хувьд хангалттай, зохистой аудитын нотлох зүйл цуглуулах боломжгүй байсныг дурдах хэрэгтэй.

Энэхүү дүгнэлтийг гаргахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай, Өмнөговь аймгийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл нь шаардлагад нийцсэн эсэх холбогдох эрхзүйн актыг шалгуур үзүүлэлт болгов.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс төсвийн тогтвортой байдлыг хангах, орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшнийг нэмэгдүүлэх, төсвийн орлогын боломжит эх үүсвэрийг дайчлах, коронавируст халдвар цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалж, нийгмийн эмзэг бүлэгт чиглүүлэх зорилтын хүрээнд Аймгийн 2021 оны төсвийн төслийг боловсруулсан байна.

Аймгийн нийт орлогыг 204,901.1 сая төгрөгөөр мөн төсвийн зарлагыг 204,901.1 сая төгрөг байхаар тус тус төсвийн төсөлд тусгажээ.

## НЭГ. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА, ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ

Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2021 оны төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

/Хүснэгт-1/

| № | Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага                                                                                                                                                                                                   | Төсвийн төсөлд тусгагдсан байдал                                                                        | Хангагдсан эсэх                                                                                               |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 6 дугаар зүйл: 6.1.1. нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон эсэх                                                                                                                                                                                 | Нэг тонн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг дунджаар 47.27 ам доллароор тооцсон байна. /Таван толгой ХК-иас/ | Сангийн яамаар хуульд нийцүүлэн хянуулж ажилласан байна.                                                      |
| 2 | 6 дугаар зүйл: 6.1.2. нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухай төсвийн жилийн ДНБ-ний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх гэсэн заалттай хэр нийцүүлсэн эсэх                                                                                | Аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй төлөвлөсөн байна.                  | Аймаг орон нутагт нэгдсэн төсвийг Сангийн яамнаас алдагдалгүй байхаар баталж өгсөн нь хуулийг хангасан байна. |
| 3 | 6 дугаар зүйл: 6.1.3. “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” нийцүүлсэн байдал | 2021 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өмнөх оноос 12.6 хувиар бууруулж тооцсон байна.   | Аймаг орон нутагт нэгдсэн төсвийг Сангийн яамнаас алдагдалгүй байхаар баталж өгсөн нь хуулийг хангасан байна. |

Эх сурвалж: Сангийн яаманд батлуулсан төсвийн төсөл, аймгийн ИТХ-д 2021 оны төсвийн төслийг хэлэлцүүлэн батлуулах төсвийн төсөл

Дүгнэлт: Өмнөговь аймгийн 2021 оны нэгдсэн төсөв нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан тусгай шаардлагуудыг хангаж байна.

**ХОЁР.****ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ**

Аймгийн нийт орлого ба тусламжийн дүнг 204,901.1 сая төгрөгөөр төсөлд төлөвлөсөн байна. Үүнд: ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 8.2%, тусгай зориулалтын шилжүүлэг 17.7%, хөрөнгө борлуулсны орлого, мал хамгаалах сангийн орлого 0.2%, байгаль хамгаалах сангийн орлого 0.1%, сумдаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1.7%, татварын орлогоос 54.7%, татварын бус орлогоос 17.4%-ийг тус тус бүрдүүлэхээр тооцжээ.

**Аймгийн 2021 оны төсвийн орлогын төлөвлөлт**

/Хүснэгт-2/

/мянган төгрөг/

| №   | Үзүүлэлт                                                            | 2020 оны<br>батлагдсан<br>төсөв | 2021 оны<br>төсвийн санал | Зөрүү дүн<br>/+ буурсан, -<br>нэмэгдсэн/ |
|-----|---------------------------------------------------------------------|---------------------------------|---------------------------|------------------------------------------|
|     | Аймгийн нийт орлого                                                 | 234,502,728.5                   | 204,901,087.4             | 29,601,641.1                             |
| 1   | Төсвийн орлого                                                      | 153,028,296.9                   | 151,995,455.6             | 1,032,841.3                              |
| 1.1 | Татварын орлого                                                     | 106,298,700.0                   | 112,172,000.0             | -5,873,300.0                             |
| 1.2 | Татварын бус орлого                                                 | 45,041,237.3                    | 35,740,415.0              | 9,300,822.3                              |
| 2   | Хөрөнгийн орлого                                                    | 58,000.0                        | 60,000.0                  | -2,000.0                                 |
| 3   | Мал хамгаалах сангийн<br>орлого                                     | 300,000.0                       | 300,000.0                 | 0.0                                      |
| 4   | Байгаль хамгаалах<br>сангийн орлого                                 | 200,000.0                       | 200,000.0                 | 0.0                                      |
| 5   | Шилжих үлдэгдэл                                                     | 30,103,555.8                    | -                         | 30,103,555.8                             |
| 6   | Сумдаас аймгийн төсөвт<br>төвлөрүүлэх орлого                        | 1,130,359.6                     | 3,523,040.6               | -2,392,681.0                             |
| 7   | Орон нутгийн хөгжлийн<br>нэгдсэн сангаас олгох<br>орлогын шилжүүлэг | 15,103,900.0                    | 16,732,100.0              | -1,628,200.0                             |
| 8   | Тусгай зориулалтын<br>шилжүүлэг                                     | 36,266,975.8                    | 36,173,531.8              | 93,444.0                                 |

Эх сурвалж: Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс

Дэлхий даяар коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийн улмаас орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө тасрах магадлалтай байна. 2021 оны төсвийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 0.7 хувиар бууруулан тооцсон байна. /Хавсралт 1/

Татварын орлого 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 14,103.0 сая төгрөгөөр тасрахаар байгаа ба орлогын тасалдлын 56.7 хувийг хувь хүний орлогын албан татвар, 42.7 хувийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, 0.6 хувийг дуудлага худалдааны орлого эзэлж байна.



Татварын бус орлого 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 13,491.6 сая төгрөгөөр тасрахаар байгаа ба орлогын тасалдлын 96.5 хувийг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, 3.4 хувийг бусад орлого тус тус эзэлж байна.

**Дүгнэлт:** Аймгийн 2021 оны төсвийн төсөлд зарим арга хэмжээ, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн орлого нэмэгдүүлэх боломж байна. Үүнд:

- Татварын багц хууль, НӨАТ-ын хуулийн хэрэгжилт НӨАТУС болон QR баримтыг Өмнөговь аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлж, хэрэгжүүлэх.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 “Энэ хуулийн 12.1.3-т заасан орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал доор дурдсан хязгаарт багтаан тогтооно”-д гэж заасныг хэрэгжүүлэн татварын баазыг тэлж, орлого нэмэгдүүлэх боломжтой.
- Монгол Улсын Их хурлаас “Малын тоо толгойн албан татварын тухай” хуулийг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлан улмаар 2021 оны 01 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөхөөр тогтсон байна. Иймд орон нутгийн суурь орлогыг 3,000.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх бололцоотой гэж үзлээ.

**Нэг малын тоо толгойд дунджаар 1.0 мянган байхаар тооцсон байдал:**

/Хүснэгт-3/


| Сум/дүүрэг  | 2019 оны жилийн эцсийн малын тоо |               |              |               |                |                | Боломжит орлогын дүн /мян.төг/ |
|-------------|----------------------------------|---------------|--------------|---------------|----------------|----------------|--------------------------------|
|             | Тэмээ                            | Адуу          | Үхэр         | Хонь          | Ямаа           | Бүгд           |                                |
| Даланзадгад | 3068                             | 3719          | 2095         | 32604         | 85626          | 127112         | 127,112.0                      |
| Баяндалай   | 4758                             | 7694          | 2777         | 39494         | 151681         | 206404         | 206,404.0                      |
| Баян-Овоо   | 7538                             | 7474          | 1705         | 45447         | 107537         | 169701         | 169,701.0                      |
| Булган      | 7254                             | 8726          | 3451         | 78673         | 138607         | 236711         | 236,711.0                      |
| Гурвантэс   | 8331                             | 4177          | 570          | 11682         | 200534         | 225294         | 225,294.0                      |
| Мандал-Овоо | 24603                            | 7413          | 1483         | 71236         | 129337         | 234072         | 234,072.0                      |
| Манлай      | 14486                            | 13633         | 2150         | 74523         | 115881         | 220673         | 220,673.0                      |
| Ноён        | 6588                             | 2633          | 276          | 12890         | 110318         | 132705         | 132,705.0                      |
| Номгон      | 9097                             | 7350          | 2414         | 48065         | 235936         | 302862         | 302,862.0                      |
| Сэврэй      | 6684                             | 6489          | 1766         | 27855         | 147686         | 190480         | 190,480.0                      |
| Ханбогд     | 31158                            | 9282          | 5951         | 51979         | 91658          | 190028         | 190,028.0                      |
| Ханхонгор   | 8034                             | 10095         | 2525         | 81655         | 178223         | 280532         | 280,532.0                      |
| Хүрмэн      | 10255                            | 6723          | 1268         | 36812         | 114831         | 169889         | 169,889.0                      |
| Цогт-Овоо   | 12633                            | 4500          | 1077         | 50830         | 85345          | 154385         | 154,385.0                      |
| Цогтцэций   | 3376                             | 9618          | 2145         | 54471         | 89845          | 159455         | 159,455.0                      |
| <b>Нийт</b> | <b>157863</b>                    | <b>109526</b> | <b>31653</b> | <b>718216</b> | <b>1983045</b> | <b>3000303</b> | <b>3,000,303.0</b>             |

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2019 оны статистикийн эмхэтгэл

- Орон нутгийн байгууллагуудын хоорондын ажлын харилцан уялдааг сайжруулах, төсвийн хариуцлагыг нэмэгдүүлснээр татварын бус орлого нэмэгдэх боломжтой гэж үзэж байна. Үүнд: Жишээ нь. Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 онд нэгдсэн удирдамжаар “Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх”-д хийсэн нийцлийн аудитаар газар эзэмших гэрчилгээг бусдад шилжүүлэхдээ эрх борлуулсны орлогыг ногдуулж, төлөөгүй зөрчилд 108.3 сая төгрөг, дуудлага худалдаа сонгон шалгаруулалтгүй газар олгосон зөрчилд 2,164.8 сая төгрөг нийт 2,273.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийн хангуулснаар энэ дүнгээр хүү торгуулийн орлого нэмэгдэх боломжтой байна.
- Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн удирдлага, менежментийг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч оны эхнээс эхлүүлэх нь зүйтэй байна.
- АТБӨЯХ-ийг албан татварт бүрэн хамруулснаар тухайн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

#### **АТБӨЯХАТ-т хамрагдсан тээврийн хэрэгсэл**

/График-1/



Эх сурвалж: Аймгийн Татварын хэлтэс

Дээрх графикаас харахад АТБӨЯХАТ-т хамрагдалт 2018 онд 86%, 2019 онд 81%, 2020 оны 10 сарын байдлаар 64%-тай байна.



## ГУРАВ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА

Аймгийн 2021 оны төсвийн нийт зарлагыг 204,901.1 сая төгрөгөөр төлөвлөн 2020 оны батлагдсан төсвөөс 29,601.6 сая төгрөгөөр буюу 12.6 хувиар бууруулан тооцсон байна. /Хавсралт 2/

### Аймгийн 2021 оны төсвийн зарлагын төлөвлөлт

/Хүснэгт-4/

| Үзүүлэлт                 |                                                           | 2020 оны<br>батлагдсан<br>төсөв | 2021 оны<br>төсвийн<br>төсөл | /мянган төгрөг/<br>Зөрүү дүн<br>/+ буурсан,<br>- нэмэгдсэн/ |
|--------------------------|-----------------------------------------------------------|---------------------------------|------------------------------|-------------------------------------------------------------|
| 1                        | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга                       | 980,517.9                       | 873,094.4                    | 107,423.5                                                   |
| 2                        | Засаг дарга                                               | 137,386,979.1                   | 80,840,089.7                 | 56,546,889.4                                                |
| 2.1                      | Урсгал зардлын дээд хэмжээ                                | 38,032,689.0                    | 54,917,865.6                 | -16,885,176.6                                               |
| 2.2                      | Хөрөнгийн зардлын дээд хэмжээ                             | 99,354,290.1                    | 25,922,224.1                 | 73,432,066.0                                                |
| 3                        | Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг | 7,772,555.7                     | 7,984,711.2                  | -212,155.5                                                  |
| 4                        | Сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлэг                 | 36,266,975.8                    | 36,173,531.8                 | 93,444.0                                                    |
| 5                        | Улсын төсөвт төвлөрүүлэх                                  | 52,095,700.0                    | 79,029,660.4                 | -26,933,960.4                                               |
| <b>Нийт зарлагын дүн</b> |                                                           | <b>234,502,728.5</b>            | <b>204,901,087.4</b>         | <b>29,601,641.1</b>                                         |

Эх сурвалж: Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс

Аймгийн 2021 оны төсвийн төсөлд төсөвт байгууллагуудад тавилга эд хогшил, гадаад албан томилолт, зочин төлөөлөгчийн зардал зэрэг зардлуудыг тусгаагүй бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 10.3%, ажил олгогчоос төлөх НДШ 9.0%, байр ашиглалтын зардал 4.3%, хангамж, бараа материалын зардал 16.2%, эд хогшил, урсгал засварын зардал 16.7%, томилолтын зардал 54.0%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 20.5%, хөрөнгийн зардлыг 79.8%-аар тус тус бууруулан тооцсон байна. /Хавсралт 3/

**Дүгнэлт:** Дэлхий даяар коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийн улмаас улс, орон нутгийн төсвийн орлого бүрдэхэд хүндрэлтэй байгаа тул төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, зарим төсвийн захирагчид тэвчиж болох зардлуудыг бууруулах нь зүйтэй байна. Үүнд:

- Аймгийн хэмжээнд нийт 16,349.5 сая төгрөгийн өртөг бүхий бүхий 398 ширхэг тээврийн хэрэгслийг төсвийн байгууллагууд албан хэрэгцээндээ ашиглаж байна. МУЗГ-ын 2015 оны “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 184 дүгээр тогтоолын дагуу Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 29 дүгээр "Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай", 2011 оны 60 дугаар "Суудлын автомашины тоог нэмэгдүүлэх" тогтоолуудыг шинэчлэн баталж суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудыг цөөлөх, төсвийн байгууллагуудын

автотээврийн хэрэгслийн ашиглалт, хамгаалалтын хяналтыг сайжруулан урсгал зардлыг бууруулах боломжтой байна.

## ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


Хөрөнгө оруулалтын зардлын дээд хэмжээг 25,922,2 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2020 оны батлагдсан төсвөөс 73.9 хувиар бууруулж төлөвлөсөн байна. Үүний дотор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг 37.9 хувиар, төсвийн хөрөнгө оруулалтыг 92.1 хувиар, байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгө оруулалтыг 28.4 хувиар бууруулсан бол замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтыг 16.3 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Мөн аудитын байгууллагад ирүүлсэн төсвийн төсөлд 2021 онд хийгдэх хөрөнгө оруулалтыг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.4.7-д заасны дагуу тооцооллыг ирүүлээгүй тул хөрөнгө оруулалтын үр өгөөж нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад дүгнэлт өгөх боломжгүй байна.

### Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ

/2020 оны батлагдсан төсөв болон 2021 оны төсвийн төслийн харьцуулалт/

/График-2/



Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 2017-2019 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд давтагдан гарсаар байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зардлыг” дахь, 6 дугаар зүйлийн 6.2 “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна” дахь заалтыг тус тус зөрчиж орон нутгийн өмчид хамаарахгүй улсын төсвийн байгууллагын урсгал болон хөрөнгө худалдан авах зардал төлөвлөж, зарцуулсан,
- Төсвийн тухай хуулийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” дахь заалтыг зөрчиж техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийгдээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан.
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагнал" -ын журмын 5.2 “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээг авч ажиллана” дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй улмаас хөрөнгө оруулалтын ажил удаашрах, хугацаанд ашиглалтад орохгүй байх, чанар муутай хийгддэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” дахь зөрчиж хөрөнгө оруулалтыг тухайн өмчлөлд хамаарах байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгаагүй гэх зэрэг нийт 4,453.3 сая төгрөгийн алдаа, зөрчил гаргасан байна.

Иймд цаашид төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналд дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллан, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой байна.

## ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох нийт орлогын шилжүүлгийг 16,732.1 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь өмнөх оноос 1,628.2 сая төгрөгөөр өссөн байна. Үүний 47.7 хувь буюу 7,984.7 сая төгрөгийг сумдын ОНХС-д, 52.3 хувь буюу 8,747.4 сая төгрөгийг аймгийн ОНХС-д хуваарилахаар тооцсон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг иргэдийн саналд үндэслэн тухайн орон нутгийн онцлогт нийцсэн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг байгуулах болон дэд бүтцийг хөгжүүлэх томоохон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн төслийн талаарх аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах ерөнхий дүгнэлтийг гаргаж байна.

- ✓ Цаашид орон нутгийн төсвийн төслийг бэлтгэхдээ Төсвийн тухай хуульд заасан зарчим болон Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас бэлтгэн гаргадаг Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжийг дагуу бэлтгэж холбогдох тооцоо, судалгаа, үндэслэлийн хамт ирүүлэхэд анхаарч ажиллах
- ✓ Иргэд болон төрийн байгууллагуудын бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбож, цахимжуулан татварын орлогыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой байна.
- ✓ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хуулиудын холбогдох заалтыг хэрэгжүүлэн татварын баазыг тэлж, орлого нэмэгдүүлэх боломжтой байна.
- ✓ Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн удирдлага, менежментийг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.
- ✓ Төсвийн байгууллагын сургалт семинар, хурал зөвлөгөөн, гадаад, дотоод албан томилолтыг цахимаар зохион байгуулан, төрөөс иргэд аж ахуй нэгжүүдэд үзүүлдэг бүх төрлийн үйлчилгээ, тусгай зөвшөөрөл олголт, халамжийн цахим системийг бий болгож зардлыг бууруулах боломжтой байна.
- ✓ Суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудыг цөөлөх, төсвийн байгууллагуудын автотээврийн хэрэгслийн ашиглалт, хамгаалалтын хяналтыг сайжруулан урсгал зардлыг бууруулах боломжтой байна.
- ✓ Хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлахдаа төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ тусгахгүй байх талаах анхаарч ажиллах.
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг иргэдийн саналд үндэслэн тухайн орон нутгийн онцлогт нийцсэн томоохон төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, сангийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

## ХАВСРАЛТ

Хавсралт-1

### Төсвийн орлого төлөвлөлт татвар нэр төрөл, тусламж санхүүжилтээр

| №          | Орлого                                                                                                                    | 2020 оны<br>батлагдсан<br>төсөв | 2021 оны<br>төсвийн<br>санал | Зөрүү дүн<br>/+ буурсан,<br>-нэмэгдсэн/ |
|------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|------------------------------|-----------------------------------------|
| <b>1</b>   | <b>Аймгийн нийт орлого</b>                                                                                                | <b>234,502,728.5</b>            | <b>204,901,087.5</b>         | <b>29,601,641.1</b>                     |
|            | <b>Төсвийн орлого</b>                                                                                                     | <b>153,028,296.9</b>            | <b>151,995,455.6</b>         | <b>1,032,841.3</b>                      |
